



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2008 оны 07 сарын 09 өдөр

Дугаар 370

Улаанбаатар хот

Гадаадад зээлээр суралцуулах,
тушаалд өөрчлөлт оруулах тухай


Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 11 дүгээр тушаалаар батлагдсан "Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам", шалгалтын комиссын дүн, захиалагч байгууллагын саналыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цэнддорж овогтой Эрдэнэбатыг Улсын Их Хурлын Тамгын газрын захиалгаар АНУ-ын Де Врай их сургуулийн магистрантурт компьютерийн ухааны чиглэлээр, Раш овогтой Оргилмааг Улсын Их Хурлын Тамгын газрын захиалгаар Австралийн Дийкин их сургуулийн магистрантурт төрийн захиргааны удирдлагын чиглэлээр, Алтангэрэл овогтой Солонгыг Канад Улсын Монреал хотын Эдийн засгийн дээд сургуульд бизнесийн удирдлагын чиглэлээр, Эрдэнэбилэг овогтой Гантулгыг АНУ-ын Феникс Ийст олон улсын нисэхийн сургуулийн мэргэжлийн нисгэгчийн ангид тус тус 2 жилийн хугацаагаар 2008-2009 оны хичээлийн жилээс Сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулсугай.

2. ОХУ-ын Эрхүүгийн Анагаах ухааны улсын их сургуулийн докторантурт суралцаж буй Галсанжав овогтой Отгоны эрдэм шинжилгээний ажлын хамгаалалтын зардлыг зээлээр олгосугай.

3. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2008 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн 294 дүгээр тушаалын Бямбацэрэн овогтой Хосбаяртай холбогдолтой хэсгийн "АНУ-ын Линкольн их сургуулийн магистрантурт" гэснийг "АНУ-ын Тейкёо Лоретто Хайтс их сургуулийн магистрантурт" гэж өөрчилсүгэй.

4. Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан "Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /Р.Бат-Эрдэнэ/-т тус тус даалгасугай.



Болормаа

Н.БОЛОРМАА